



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 09 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал,
амралтын газрын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Холбоо ус ХХК-ийн “Чандмань” зочид буудлын 17/304, Улаанбаатар зочид буудал ХХК-ийн “Улаанбаатар-2” зочид

1150500001

буудлын 17/312, “Улаанбаатар зочид буудал” ХХК-ийн “Улаанбаатар” зочид буудлын 17/311, Премиум Палас ХХК-ийн “Премиум” зочид буудлын 18/02, Ой мод ХХК-ийн “Хараа” зочид буудлын 17/317, БПСБ ХХК-ийн “Тото” зочид буудлын 17/319, Сан хорго групп ХХК-ийн “Сан” зочид буудлын 18/01, Дэлгэрэнт трейд ХХК-ийн “Санрайс” зочид буудлын 17/295, Плийдс ХХК-ийн “Севен” дэн буудлын 17/333, Цоглог хараа ХХК-ийн “Элит” дэн буудлын 17/329, Сан жуулчин ХХК-ийн “Сан” жуулчны баазын 18/10 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.


6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага, жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА *D. Batsukh* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 01
сарын 09 өдрийн А/01 дүгээр
тушаалын нөгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.01.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Холбоо ус ХХК	2601273	Чандмань	СХД-ийн 15-р хороо, Барилгачин гудамж – 36
2	Улаанбаатар зочид буудал ХХК	2026864	Улаанбаатар -2	Налайх дүүрэг, 6-р хороо, Тэрэлж гудамж 48-7 тоот
3	Улаанбаатар зочид буудал ХХК	2026864	Улаанбаатар	СБД-ийн 8-р хороо, Бага тойруу 14200
4	Премиум Палас ХХК	5933463	Премиум	Чингэлтэй дүүрэг, 5-р хороо Тасганы овоо /15150/, Их тойруу гудамж-21 байр
5	Ой мод ХХК	2095254	Хараа	ЧД-ийн 2-р хороо, Чоймболын гудамж 6 тоот
6	“БПСБ” ХХК	5149967	Тото	БГД-ийн 4-р хороо, ЭТӨЧ 76 тоот
7	Сан хорго групп ХХК	2856417	Сан	ЧД-ийн 6-р хороо, Их тойруу-47

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 01
сарын 09 өдрийн А/01 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт

5264325 СБТ-88936 1118263502


ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.01.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Плийдс ХХК	5269342	Севен	СБД-ийн, 9-р хороо Алтайн 12 – гудамж, 364 тоот
2	Аяама-Амаяа ХХК	5917972	Ийгл	БГД-ийн, 23-р хороо, Хувьсгалын зам 10 тоот
3	Цоглог хараа ХХК	2542625	Элит	Налайх дүүрэг, 2-р хороо, Жаргалантын 64 тоот
4	Дэлгэрэнт трейд ХХК	2613093	Санрайс	БЗД-ийн 13-р хороо, Нарны зам, Алтантэвш амины орон сууцны хороолол-124

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 01
сарын 09 өдрийн А/01 дүгээр
тушаалын гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.01.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сан жуулчин ХХК	2627981	Сан	Налайх дүүргийн 6-р хороо, Өвөр урианхайн ам